



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



Economic Policy Reform and
Competitiveness Project

ЭЗБШӨЧ ТӨСЛИЙН САР ТУТМЫН ЦУВРАЛ

2008 оны 7 дугаар сар

Хэрэглэгчийн цахилгаан, дулааны шинэ тариф

Эрчим хүчний зохицуулах газрын (ЭХЗГ) энэ оны 6 дугаар сарын 30-ны өдрийн тогтоолын дагуу 7 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн цахилгааны үнэ 28 хувь, дулааны үнэ 39 хүртэл хувиар тус тус нэмэгдэхээр боллоо. Уг тогтоолын дагуу цахилгааны өссөн шатлалтай тарифыг нэвтрүүлж, шөнийн тарифыг шинэчилжээ. Цахилгааны хэрэглээ шөнийн цагт бага байдаг учраас тарифыг доогуур тогтоодог. Тарифын шинэ загвар нь шөнийн тарифыг хамгийн доод буюу суурь үнийн түвшинд хүргэж нэмэгдүүлэх замаар цагийн ялгавартай тарифыг боловсронгуй болгон улмаар эрчим хүчний хэмнэлт, эрэлтийн талын менежментийг хэрэгжүүлэх үүднээс цахилгааны тарифыг шат дараатай нэмэгдүүлэх шинэ

тарифыг багаар тогтоохоор болжээ.

Хэрэглэгчдийн тарифыг нэмэгдүүлсэн явдал нь Төвийн эрчим хүчний системийн таван ДЦС-д тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг үзүүлэх анхны арга хэмжээ юм. Сүүлийн үед Багануурын нүүрсний үнэ 29.6, Шарын голынх 27.3, Шивээ-Овоогийнх 34.1 хувиар нэмэгдсэн, мөн зарим сумдыг цахилгаанаар хангах өргөтгөлийн ажлууд хийгдэж байгаа нь санхүүгийн хүнд байдалд хэдийнээ ороод байгаа эдгээр цахилгаан станцуудыг улам бүр хүндрүүлж байна.

Хэрэглэгчийн цахилгаан, дулааны одоогийн тарифыг үйлчилгээний зардлыг нөхөх хэмжээнд тогтоогоогүй бөгөөд энэ хоёр үйлчилгээг аль болох зохистой түвшинд үзүүлэхийн тулд хөндлөн татаасыг ашиглаж байна. ЭХЗГ-аас саяхан баталсан өссөн шатлалтай тарифаар бага орлоготой хэрэглэгчдийн тарифыг багаар тогтоосон боловч үзүүлж буй үйлчилгээний зардал болон илүү өндөр орлоготой хэрэглэгчдийн төлж буй төлбөр хоорондын зөрүүг багасгахад чиглэсэн алхам боллоо. Ерөнхийдөө үйлчилгээний зардлыг нөхнө гэвэл бодит тарифыг дунджаар 60 хувиар нэмэх шаардлагатай байгаа юм.

ЭХЗГ-аас цахилгаан, дулааны үнэ тарифыг зохистой болгох талаар авсан эдгээр арга хэмжээ нь тус газар болон ЭЗБШӨЧ төслийн хамтран боловсруулсан Хэрэглэгчийн тарифыг өөрчлөн шинэчлэх төлөвлөгөөний нэг хэсэг нь байв. Энэхүү төлөвлөгөө нь 2012 он гэхэд хэрэгжиж дуусах бөгөөд уг төлөвлөгөөний хүрээнд хэрэглэгчийн тогтмол хураамж, чадлын тарифыг нэвтрүүлэх, ачааллын талаар судалгаа хийх, хөндлөнгийн татаасыг багасгах, зардал нөхөх хэмжээнд тариф тогтоох, хэрэглэгчийн ангиллыг хянах зэрэг үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар хэрэглэгчийн тарифын загварыг улам боловсронгуй болгох арга хэмжээнүүд багтжээ.

Хэрэглэгчийн өссөн шатлалтай тарифын бүтцийг хэрэглэгчийн ангилал, бүсээр харуулсан дэлгэрэнгүй мэдээллийг ЭХЗГ-ын дараах вэбсайтаас үзнэ үү: <http://www.era.energy.mn/mon/index.php>.

аргачлалыг нэвтрүүлэх замаар төлбөрийн чадвар муутай эмзэг бүлгийнхнийг үнийн өсөлтөөс хамгаалах юм.

Хэрэглэгчийн цахилгааны шатлалтай тарифын дагуу сард 150 кВт хүртэл цахилгаан хэрэглэдэг хэрэглэгчид нэг кВт.ц тутамд 60 төгрөг, 250 кВт.ц хүртэл хэрэглээтэй хэрэглэгчид 64 төгрөг, сард 250 кВт.ц дээш хэрэглээтэй хэрэглэгчид нэг кВт.ц тутамд 68 төгрөг төлөх болж байна. Цахилгааны ижил хэрэглээтэй гэр хорооллын хэрэглэгчдийн хувьд сарын шаталсан тарифаар нэг кВт.ц тутамд 58, 62, 66 төгрөг тус тус төлнө. Өөрөөр хэлбэл сард 150 кВт.ц-аас бага цахилгаан хэрэглэдэг гэр хорооллын хэрэглэгчид сардаа 8700 хүртэл төгрөг төлөх болж байгаа нь орон сууцны оршин суугчдын нэг кВт.ц төлөх төлбөрөөс 2 төгрөгөөр бага байгаа юм.

Цагийн ялгавартай ийм тарифыг нэвтрүүлэх болсон нь цахилгаанаас дулаанд шилжих хөндлөнгийн татаастай холбоотой гэж ЭХЗГ үзэж байна. Харин олон нийтийг инфляцийн өсөлтөөс хамгаалах Засгийн газрын санаачлагыг дэмжихийн тулд Троллейбусны компани, Алтан тариа, Улаанбаатар гурил, Талх чихэр, Атар өргөө компаниудын

Санхүүгийн зохицуулах хороо ипотекийн зах зээлийн нэр томъёо, тодорхойлолтуудын Монгол тайлбар толь гаргана

Санхүүгийн зохицуулах хорооноос (СЗХ) ипотектэй холбоотой нэр томъёо, тодорхойлолтуудын тайлбар толь боловсруулж дуусгасан бөгөөд энэ 9 дүгээр сард албан ёсоор гаргахаар төлөвлөж байна. Тайлбар толинд хууль эрх зүйн болон санхүүгийн хүрээнд хэрэглэдэг ойлголт, тодорхойлолтууд, тэдгээрийн монгол нэр томъёо орж байна.

Энэхүү товхимлыг хууль эрх зүйн болон санхүүгийн хүрээнд ерөнхийдөө хүлээн зөвшөөрөгдсөн стандарт хэллэг, ойлголтуудыг Монгол улсад бий болгох, хэвшүүлэх зорилгоор боловсруулж, ипотекийн анхдагч, хоёрдогч зах зээлийн хууль

Энэхүү цувралд нийтлэгдсэн санаа бодол нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон АНУ-ын Засгийн газрын байр суурийг заавал илэрхийлсэн байх албагүй болно.

эрх зүйн болон зохицуулалтын ажиллагаанд оролцдог хүмүүст үндсэндээ зориулж байгаа юм. Ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээл, тэдгээрт оролцогчид, хэлцлүүдийн талаархи ерөнхий ойлголтыг хялбар болгох үүднээс товхимолд дараах нийтлэг ойлголтуудыг тайлбарласан бүдүүвч зургийг мөн орууллаа. Үүнд:



- Ипотекийн анхдагч зах зээлийн үйл ажиллагаа
- Хоёрдогч зах зээлийн дахин санхүүжилт
- Ипотек (хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас)
- Ипотекээр баталгаажсан Европ загварын өрийн бичиг

2007 онд СЗХ нь төслийн туслалцаатайгаар орон сууцны санхүүжилт, хөрөнгийн зах зээлийн хөгжлийн эрх зүйн болон зохицуулалтын илүү таатай орчин бүрдүүлэх зорилгоор үнэт цаасжуулалтын тухай хоёр хуулийн төсөл боловсруулсан билээ. Эдгээр хуулийн төслийн зорилго нь барьцаат ипотекийн бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гэгдэх санхүүгийн хэрэгслүүдийн зохицуулалтыг хангах замаар хувийн хэвшил давамгайлсан өрсөлдөөн бүхий хоёрдогч зах зээл, үүний дотор ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршиж байгаа юм. Эдгээр нь банк, санхүүгийн бусад байгууллагуудад хөрөнгийн зах зээлээс урт хугацааны, зардал багатай санхүүжилт татах боломж олгох юм.

Хэдийгээр ипотекийн зах зээл маш их хурдацтай өсч хөгжиж байгаа ч ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн мэргэжлийн хэллэг нэр томъёо, үндсэн үйл ажиллагаа нь бодлого боловсруулагчид, олон нийтэд төдийлөн танил биш байна. Тайлбар толь нь энэ хэрэгцээг хангаж, монгол хэл дээрх эрх зүйн холбогдох нэр томъёо, тодорхойлолтуудыг нэг мөр болгохыг зорьж байгаа юм.

Ипотекийн тайлбар толь боловсруулах ажил нь олон нийтийн боловсролыг дээшлүүлэх кампанит ажлын нэг хэсэг байсан бөгөөд үүнийг СЗХ-ноос 2007 оны 8 дугаар сард үнэт цаасжуулалтын тухай хуулийн төслүүд дээр зохион байгуулсан семинарын үеэр банк, санхүүгийн байгууллагууд, хуулийн төсөл боловсруулагчдаас гаргасан санал, УИХ-ын зарим гишүүдийн хүсэлтийн дагуу гүйцэтгэлээ. Ингэхдээ ипотекийн зах зээлийн үйл ажиллагаа, тэдгээрт үйлчилдэг хууль журмуудын талаархи ойлголтыг хялбаршуулах зорилгоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Барьцаат ипотекийн бондын тухай хуулийн төслүүдэд орсон эрх зүйн холбогдолтой бүх нэр томъёог багтааж оруулахад голлон анхаарсан юм.

СЗХ-ноос 2008 оны 9 дүгээр сард ипотекийн тайлбар толийг албан ёсоор гаргах болно. Олон нийтийн зүгээс энэхүү товхимлыг СЗХ-ны www.frc.mn вэбсайтаас цахим хэлбэрээр авах боломжтой. Харин албан ёсоор гаргах хүртэлх хугацаанд уг товхимлыг төсөл болох хувилбарыг ЭЗБШӨЧ төслийн www.eprc-chemonics.biz/ вэбсайтаас PDF форматаар авч болно.

Замын-Үүд дэх хилийн боомтын гааль, мэргэжлийн хяналтын талбайн шинэ зураг төслийг гаргах ажил дууслаа



Улсын Мэргэжлийн Хяналтын Газар (УМХГ), Гаалийн Ерөнхий газар (ГЕГ), Азийн Хөгжлийн Банкны (АХБ) зөвлөхүүд болон уг ажлыг гүйцэтгэж буй дотоодын түнш байгууллага болох "Эрчим" ХХК-ийн төлөөлөгчид ГЕГ-ын байранд 7 дугаар сарын 1-ний өдөр зохион байгуулсан уулзалтад оролцож, Замын-Үүд боомтын гааль, мэргэжлийн хяналтын талбайн урьдчилсан зураг төслийн талаар ярилцлаа. Уулзалтыг ЭЗБШӨЧ төслийн шугамаар ирсэн байгууламжийн инженер ноён Камал Пател удирдан явуулав.

Уг уулзалтын гол зорилго нь Замын-Үүд дэх гааль, мэргэжлийн хяналтын талбайн инженерийн ажлын шинэ зураг төслийг гаргах зорилгоор ГЕГ дээр байгуулсан ажлын хэсэгт туслалцаа үзүүлэх үүднээс 6 дугаар сарын 2-оос хойш хийж гүйцэтгэсэн ажилтай танилцахад оршиж байв. Санал болгож буй зураг төслийн дэд бүтцийн тусгайлсан бүрэлдэхүүн хэсгүүдэд дараах орж байна. Үүнд:

- Хилээр орж ирэх ачааны машинд зориулсан шинэ автозам
- Нэмэлт пүү
- Өргөтгөн шинэчилсэн автомашины зогсоол болон хяналтын талбай
- Ачааг дэлгэж шалгахад зориулсан тавцан

- Түр зогсоол гаргаж өөрчлөн шинэчилсэн зам
- Рентгенд хүргэх дотоод автозамын коридор
- Рентген нэмж суурилуулах боломж



Гааль, мэргэжлийн хяналтын одоогийн байгууламжуудын талбай бага, зохион байгуулалт оновчгүй байгаа нь Эрээн хотоос Монгол улс руу эсвэл Монгол улсаар дамжин бусад улс орнуудад автозамаар ачаа тээвэрлэх хөдөлгөөнийг хүндрүүлж буй хамгийн гол саад бэрхшээлүүдийн нэг болоод байна. Үүнээс гадна байгууламж доторхи автозамыг сайжруулах төслийн хүрээнд хийгдсэн замын ажлыг чанаргүй гүйцэтгэснээс амархан эвдэрч муудаж байна.

Шинэ зураг төсөл гаргах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэх зорилготой байв. Үүнд:

- Хяналтын ажлыг хөнгөвчилж, ачааны машины эргэлтийг түргэвчлэх үүднээс хяналтын талбайг өргөтгөх
- Зорчигч тээврийг ачаа тээврийн хөдөлгөөнөөс тусгаарлах
- Ачаа тээврийн хөдөлгөөнийг ачааны төрлөөр салгах: ижил барааг рентген рүү шууд явуулах, холимог ачааг хяналтын талбай руу явуулах

ЭЗБШӨЧ төслөөс эдгээр байгууламжийг өргөтгөн шинэчлэх ажлыг хариуцан гүйцэтгэж буй байгууллага болох ГЕГ, УМХГ-т туслалцаа үзүүлсээр ирлээ. Монгол Улсын Засгийн газраас эдгээр байгууламжийг өргөтгөн шинэчлэхэд зориулж 2008 оны төсвөөс 2.5 тэрбум төгрөгийг ГЕГ-т байршуулжээ. ГЕГ нь иргэний барилга байгууламжийн ажлын тендер зарлаж, барилга угсралтын ажилд хяналт тавих юм.

Олон улсын зөвлөх Камал Пателийн зүгээс уулзалт хийсэн хугацаа болон эдгээр байгууламжийг маш шахуу хугацаанд барьж дуусгах графикийг харгалзан инженерийн ажлыг Монгол улсад урьд өмнө нь хэрэгжиж байгаагүй "зураг гаргах-барих" гэрээ байгуулан нэг компаниар гүйцэтгүүлэхийг зөвлөмж болгосон юм. Гэвч уулзалт болсноос хойш тендер зарлах асуудлыг УИХ-аар 2008 оны төсвийн тодотгол батлах хүртэл хойшлуулах болсон тухай ГЕГ-аас мэдэгдээд байна. Иймд шинэ байгууламжуудыг барих ажил 2009 он хүртэл хойшлогдох болж байна.

Санхүүгийн зохицуулах хороо хувьцааг нийтэд санал болгох ажиллагааны (ХНСБ) шинэ журам гаргахаар төлөвлөж байна

Энэ 7 дугаар сарын 1-ний өдөр хувьцааг нийтэд санал болгох хэлцлүүдийг Санхүүгийн зохицуулах хорооноос (СЗХ) батлах, тэдгээрийг Монголын хөрөнгийн биржид (МХБ) бүртгүүлэх, хяналт тавихтай холбоотой зохицуулалт, бодлого, дүрэм журмыг шинэчлэх талаар санал болгож буй зөвлөмжүүдийг танилцуулсан презентацид нийт 89 оролцогчид, үүний дотор Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын 9



ажилтан, Үнэт цаасны брокеруудын холбоо, дилерүүд, Монголын Хөрөнгийн Корпораци, БиДиСек зэрэг 38 компанийн 65 төлөөлөгчид, СЗХ-ны мэргэжлийн сургалтын курсын 15 оюутан оролцлоо. Уг презентаци нь хувьцааг нийтэд анх санал болгох ажиллагааны зохицуулалтыг судалж гаргасан анхны зөвлөмжүүдийн талаар харилцан ярилцах боломжийг салбарынханд олгосон бөгөөд энэ арга хэмжээнд СЗХ-нд Төслөөс туслалцаа үзүүлсэн юм. Ярилцлагыг Санхүүгийн зах зээлийн зохицуулалтын мэргэжилтэн Клиффорд Кеннеди удирдан явууллаа.

ХНСБ зах зээлийн зохицуулалтын журам нь СЗХ байгуулагдсан 2006 оноос үйлчилж эхэлсэн боловч хувьцаагаа нийтэд зарж борлуулах сонирхолтой үнэт цаас гаргагчийн хувьд дагаж мөрдөх ерөнхий удирдамж, зааварчилгаа байхгүй өнөөг хүрчээ. Үүний улмаас ХНСБ бэлтгэл ажлыг хангах, хянаж шалгахад цаг хугацаа их орж, эдгээрийг дуусгахад бараг дөрвөн сар зарцуулж байгаа юм. СЗХ нь 2008 оны эхнээс ХНСБ нийт арван хоёр өргөдөл хүлээн авсан бөгөөд эдгээр нь бүгд хяналт, судалгааны шатандаа явж байна.

ХНСБ ажиллагааны зохицуулалт, дүрэм журмыг судалж, санал болгосон зөвлөмжүүдийг хэрэгжүүлснээр тэдгээрийг Олон улсын үнэт цаасны хороо (ОУҮЦХ/IOSCO), ЕХ-ны Танилцуулгын удирдамж/чиглэл, АНУ-ын Үнэт цаасны хорооны (АНУ-ын ҮЦХ/SEC) журам, хэвлэж гаргасан удирдамжид багтсан олон улсын шилдэг туршлагатай нийцүүлэх юм. ХНСБ хэлцлийг батлах, хөрөнгийн биржид бүртгүүлэх, хяналт тавих одоогийн журам нь үнэт цаас гаргагчид, андеррайтеруудаас ХНСБ бэлтгэл ажлыг удирдан зохицуулахад хангалттай удирдамж чиглэл болж чадахгүй байна. Үүний улмаас үнэт цаас гаргагчид болон андеррайтерууд ХНСБ өргөдөл, танилцуулгыг СЗХ-гоор батлуулах хэмжээнд боловсруулахад ихээхэн цаг хугацаа шаардагдаж байна. Үүнээс гадна дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахын тулд ХНСБ ажиллагааны одоогийн зохицуулалт, дүрэм журмыг зайлшгүй шинэчлэх шаардлагатай.

Презентацийн үеэр дараах зөвлөмжүүдийн талаар ярилцлаа. Үүнд:

Ил тод байдлын стандартыг сайжруулах. Энэ нь хувьцааны үнэт цаас, ХНСБ, хоёрдогч зах зээл дээр нийтэд санал болгох, хөрөнгийн биржид үнэт цаасыг бүртгүүлэхэд

ашигладаг бичиг баримтуудад холбогдох мэдээллийг ил тод болгох талаар ОУҮЦХ, Европын Холбоо, АНУ-ын ҮЦХ-ноос тогтоосон үндсэн зарчмуудад, мөрдөгддөг ил тод байдлын стандартуудад суурилсан байвал зохино.

Боломжит хөрөнгө оруулагчдад зориулсан товч танилцуулга*. Нийтийн ашиг сонирхолд үйлчлэх үүднээс Товч танилцуулга гаргаж, ХНСБ хэлцэлд оролцох боломжит хөрөнгө оруулагчдад уг танилцуулгыг түгээх шаардлагыг тухайн үнэт цаас гаргагчид тавих нь зүйтэй. Товч танилцуулга нь "уншигчдад ээлтэй" байж, үнэт цаас гаргагч, эрсдэлийн хүчин зүйлс болон бусад чухал ач холбогдолтой асуудлуудын талаар тойм мэдээллээр хангахын зэрэгцээ нийтэд анх санал болгож буй хувьцааг худалдан авах өргөдөл гаргасан бүх хүмүүст хүрсэн байвал зохино.

Санхүүгийн тайланд удирдлагын ярилцлага, дүн шинжилгээг оруулах шаардлага. Удирдлагын тайлан, дүн шинжилгээг (УТДШ) санхүүгийн тайланд оруулах нь олон улсын стандарт болж байна. УТДШ нь компанийн ашиг орлого, мөнгөн урсгалын бүрэлдэхүүн хэсгүүдийн тухай мэдээллээр хангаж, санхүүгийн нарийн төвөгтэй тайлан баланс, эрсдэлийн хүчин зүйлүүдийг илүү ойлгомжтой болгоход тусалдаг. Тухайн компанийн санхүүгийн ирээдүйн байдал, үйл ажиллагаанд материаллаг байдлаар нөлөөлж болох хүчин зүйлс, чиг хандлагыг үнэлсэн удирдлагын үнэлгээг ил тод байлгах нь хөрөнгө оруулагчдад уг компанийг удирдлагын нүдээр харах боломж олгодог. Тиймээс СЗХ-ны ХНСБ талаархи шинэчилсэн журамд энэхүү шаардлагыг авч үзэх нь зүйтэй юм.

Танилцуулга тараах. Монгол улсад нийтэд санал болгох хувьцааны талаархи мэдээллийг тэр бүр тараахгүй байна. Мэдээлэл тараах ажиллагааны хүндрэлийг шийдвэрлэхийн тулд хувьцааг нийтэд санал болгох ажиллагаа дуусгавар болох хүртэлх хугацаанд танилцуулгын төсөл, эцсийн танилцуулгыг СЗХ-ны вэбсайтад байршуулж болно. Түүнчлэн танилцуулгыг СЗХ, МХБ, андеррайтер болон тухайн компаниас авах боломжтой байвал зохино.

Дүн шинжилгээ. Андеррайтеруудаас хийдэг зохих дүн шинжилгээ, практик ажиллагааг сайжруулах шаардлагатай байна. Андеррайтер нь тухайн үнэт цаас гаргагчийн бизнесийн болон бусад ажиллагааны талаар сайтар ойлголттой байж үнэт цаасыг итгэлтэйгээр санал болгож худалдах, мөн үйлчлүүлэгчид нь үнэт цаас гаргагчийн эрх зүйн, санхүүгийн болон бизнесийн байдлын талаар бүрэн мэдээлжсэн байх баталгааг хангахын тулд хангалттай судлах ёстой. СЗХ нь андеррайтерийн ажиллагааг, тухайлбал үнэт цаас гаргагчийн талаар зохих дүн шинжилгээ хийлгүүлэх ажлыг гүйцэтгүүлэхийн тулд зохих арга хэмжээ авах шаардлагатай.

Дүрэм журмын өөрчлөлт. СЗХ нь өөрийн байгууллагын хүрээнд ХНСБ ажиллагааг хянах, шийдвэрлэх ажиллагааг сайжруулахын тулд зохих зааварчилгаа, захирамж, заавар, танилцуулга, гаргасан материалыг өргөнөөр ашиглахад, мөн бусад арга хэмжээнд анхаарлаа хандуулах нь зүйтэй. ХНСБ-ыг хянаж шалгах ажиллагааны үр ашгийг сайжруулахад зөвхөн зохицуулалтын хяналтын хуудас/ жагсаалтыг ашиглах нь хангалтгүй юм. Санхүүгийн байгууллагуудтай ярилцсан ярилцлагаас үзэхэд СЗХ-ноос гаргасан албан ёсны олон тооны удирдамж зааварчилгаа, тодруулга, мөн дүрэм журмуудыг хөнгөвчлөх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

СЗХ-ны ажилтнуудын сургалт. Түүнчлэн СЗХ-ны ХНСБ өргөдөл, танилцуулгыг хянаж шалгах ажил эрхэлдэг мэргэжлийн ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөртэй болохыг СЗХ-нд мөн зөвлөмж болгож байна. Үүний тулд СЗХ нь эдгээр ажилтнуудад зориулсан дүрэм журмуудыг багтаасан гарын авлага, сургалтын гарын авлага боловсруулахад анхаарах шаардлагатай.

СЗХ-ны ХНСБ зах зээлийн одоогийн зохицуулалт, дүрэм журмуудын талаархи нарийвчилсан үнэлгээ, тэдгээрийг олон улсын шилдэг туршлагад ойртуулах зөвлөмжүүдийг удахгүй гарах төслийн тайланд оруулсан болно.

*Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны сар тутмын цахим хэвлэл юм. Та өөрийн санал бодол, манай цувралыг захиалах буюу захиалгаа цуцлах хүсэлтээ ЭЗБШӨЧ төслийн цуврал хариуцсан эрхлэгчид дараах хаягаар ирүүлнэ үү.
И-мэйл fbertoli@eprc-chemonics.biz, факс: (976-11) 32 78 25.*